



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 1770

Арвайхээр

Урамшуулал олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 19 дүгээр зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ амжилттай биелүүлж “Төсвийн орлогыг нэмэгдүүлэх, татвар хураалтыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2018 оны 05 дугаар албан даалгаврыг үр дүнтэй зохион байгуулж аймгийн төсөвт 2 сарын хугацаанд 130.6 сая төгрөгийн торгуулийн орлогыг төвлөрүүлж ажилласан тул аймгийн Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хурандaa О.Ганбат)-д албан тушаалын нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгосугай.
2. Мөнгөн урамшууллыг аймгийн Цагдаагийн газрын төсвөөс гаргахыг тус газрын нягтлан бодогч (Г.Нацагханд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД

011101632

D:My Doc. Zahiramj. Zasag darga